

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 22 тоот тогтоолоор батлав.

МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ҮЭ-ИЙН ХОРООДЫН ТАЙЛАН, СОНГУУЛИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

1. ҮЭ-ийн хороод нь МЭХГУУ-н ҮЭ-ийн холбооны дүрмийн 4.4-т “ҮЭ-ийн хороо нь бүх гишүүддээ жил бүр тайлангаа тавьж 4 жилд 1 удаа сонгууль явуулах бөгөөд зайлшгүй тохиолдол болон гишүүдийн олонх нь сонгууль явуулахыг шаардсан нөхцөлд хугацаа харгалзахгүй хурлаа хийнэ” гэсэн заалтын дагуу хурлаа зохион байгуулна. Тайлан сонгуулийн хурлыг хугацаанд нь зохион байгуулаагүй тохиолдолд холбооны зүгээс хурлыг хуралдуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авна.
2. Тайлан сонгуулийн хурлын хугацаа, хэлэлцэх асуудлыг хурал хуралдахаас 10-аас доошгүй хоногийн өмнө ҮЭ-ийн хорооны тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж зарлана. Орон нутаг, үйлдвэрлэл үйлчилгээний онцлогоос шалтгаалж тайлан сонгуулийн хурлыг хэсэгчилж, төлөөллийн, бүх гишүүдийн хурал хэлбэрээр зохион байгуулж болно.
3. Хуралд бэлтгэх, сонгууль явуулах комиссыг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж батална.
4. Тайлан сонгуулийн хуралд бүх гишүүд оролцох боломжгүй тохиолдолд төлөөлөгч сонгон оролцуулж болно. Төлөөлөгчдийн тоог нэрчилсэн бүртгэлийг үндэслэн тогтоох бөгөөд нэг гишүүдийн төлөөлөх тоог ҮЭ-ийн хорооны тэргүүлэгчдийн хурлаас тогтооно.
5. Бүх гишүүдийн хуралд нийт гишүүдийн 50-иас доошгүй хувийг оролцуулна. Хурлын ирцэд амралт, томилолт, чөлөөтэй, өвчтэй болон үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагаанд оролцож байгаа ажилтнуудыг оруулж тооцохгүй.
6. Тайлан сонгуулийн хурлаар:
 - ҮЭ-ийн хорооны тайлан
 - Хяналтын хорооны тайлан
 - ҮЭ-ийн хорооны дарга, тэргүүлэгчид
 - ҮЭ-ийн хорооны нягтлан бодогч
 - Хяналтын хорооны гишүүд
 - Хөдөлмөрийн маргаан таслах комиссын ажилчдын төлөөлөлийг сонгож батлана.
7. Тайлан сонгуулийн хурал дараах дарааллаар явагдана.
 - 7.1 ҮЭ-ийн хорооноос хийсэн ажлын тайлан
 - 7.2 Хяналтын хорооны тайлан
 - 7.3 ҮЭ-ийн хорооны дарга, идэвхтэн, сонгуультаан сонгох
8. Тайлан сонгуулийн хуралд бэлтгэх, сонгууль явуулах комисс нь ҮЭ-ийн хорооны даргын сонгуульд нэр дэвшиж өрсөлдөх хөдөлмөрийн насны, салбарын ҮЭ-ийн хороонд татвар төлдөг хүмүүсийн анкет, мөрийн хөтөлбөрийг хүлээн авах бөгөөд материал хүлээн авах хугацааг хурал болохоос 24 цагийн өмнө дуусгавар болгоно.
9. Нэр дэвшигчдэд тавигдах шаардлага болон сонгууль явуулах журмыг тухайн анхан шатны ҮЭ-ийн хороо тэргүүлэгчдээрээ хэлэлцэж батална.
10. ҮЭ-ийн хорооны тайлан сонгуулийн бүх гишүүдийн хурлын ирц 50-иас дээш хувь хүрэхгүй бол сонгууль явуулахгүй.
11. ҮЭ-ийн хорооны даргыг сонгох сонгуулийн санал хураалтыг илээр буюу нууцаар санал хураах асуудлыг тухайн хамт олон өөрсдөө шийдвэрлэнэ. Хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ҮЭ-ийн хорооны дарга, идэвхтэн, сонгуультааныг сонгож бүх гишүүдийн хурлын тогтоолоор батална.